



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/40

Мандалговь

**Хурдан морины уралдаан зохион
байгуулахыг хориглох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 6 дугаар зүйлийн 6.2, 24 дүгээр зүйлийн 24.3, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/36 дугаар тушаалаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ын 3.10.2, Засгийн газрын 2019 оны 1/10 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны А/54 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан бооцоот уралдаан мялаалга найрын уралдаан, уралдааны өмнөх үсэргээ, сунгаа зохион байгуулах, оролцохыг хориглосугай.

2. Өвөл хаврын байгаль цаг агаарын таагүй нөхцөл морины уралдааны үед үүсч болзошгүй сөрөг нөлөө, үр дагаврыг олон нийт, ялангуяа уяачид эцэг эхчүүдэд цаг алдалгүй сурталчилж захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг хөдөөгийн багийн Засаг дарга, баг, сургуулийн нийгмийн ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд онцгой хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (О.Уранзаяа), сумын хэсгийн байцаагч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

